



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ДОТООД АУДИТЫН АЛБА

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100

Утас: (976) 7010 1388, 7010 1408

Цахим шуудан: contact@internalaudit.ub.gov.mn

Цахим хуудас: www.internalaudit.ub.gov.mn

2025.08.20 № 2/176
танай _____-ны № _____-т

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАРТ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн баталсан 2025 оны 09 дүгээр удирдамжийн дагуу танай байгууллагын 2023, 2024 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт шалгалтын тайланг хүргүүлж байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА



З.ОТГОНБАЯР

D:\2025\Явуулсан албан бичиг\A5 кириль.docx

1725020194

Хяналт шалгалтын газрын үйл ажиллагаанд хийсэн аудит хяналт шалгалтаар илэрсэн асуудал

/мянган төгрөгөөр/

№	Илэрсэн асуудлын утга	Холбогдох хууль тогтоомж	Нийт илэрсэн асуудал	Үүнээс		
				акт	Албан шаардлага	Зөвлөмж
1	Хяналт шалгалтын газар нь Смарт зон ХХК-тай 24/11 дугаартай худалдан авах гэрээг 2024 оны 11 дүгээр сарын 01-нд байгуулж, 3,050.0 мянган төгрөгийн Floor stand 55 инч ухаалаг дэлгэц худалдан авсан боловч данс бүртгэлд тусгаагүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", НИТХ-ын 2014 оны 66 дугаар тогтоолын 3.2.4 "Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслээс бусад хөдлөх эд хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн дарга /захирал/-ын тушаалаар бүртгэнэ" гэсэн заалтыг мөрдөөгүй байна.	3,050.0			3,050.0
2	Шунхлай трейдинг ХХК-тай Т/117 тоот шатахуун нийлүүлэх гэрээг 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдөр байгуулж, нийт 13,440.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авсан. Гэрээний 5.2 "Шатахууны урамшууллыг мөнгөн талоны хэлбэрээр олгоно", 5.3 "Урамшууллыг зөвхөн шатахууны талоны үнийг урьдчилан төлсөн тохиолдолд худалдан авсан мөнгөн дүнгийн 3% тооцон урамшуулал олгоно" гэж заасны дагуу 403.2 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг данс бүртгэлд тусгаагүй /орлогод аваагүй/ байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэл хөтлөх. 14.4.1 "аж ахуйн бүх ажил гүйлгээ" хөтөлнө гэсэн заалтыг мөрдөөгүй байна.	403.2			403.2
3	Тайлант 2024 онд Хотын стандарт, хяналтын газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар 28,034.9 мянган төгрөгийн хангамжийн материал актлах тушаал гарсан байтал 29,086.6 мянган төгрөгийн БМ акталж, 1,051.7 мянган төгрөгийн БМ-ыг тушаал шийдвэргүйгээр акталсан	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4. "Үнэн зөв байх", 13 дугаар дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.	1,051.7			1,051.7
4	НАОБТГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн Шилжүүлэн ажиллуулах тухай Б/66 дугаар тушаалаар Байгальд ээлтэй технологи, сэргээгдэх эрчим хүч хариуцсан мэргэжилтэн Э.Цогзолмааг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөр тасалбар болгон Нийслэлийн Хяналт, шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагчаар томилохдоо ээлжийн амралтын тооцоо хийсэн байтал Нийслэлийн хяналт шалгалтын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн Б/113 дугаар Э.Цогзолмаад мөнгөн урамшуулал олгох тухай тушаалаар ээлжийн амралтаа ажлын зайлшгүй шаардлагаар биеэр эдэлж чадаагүй тул 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх урамшууллыг давхардуулан олгосон байна.	Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг мөрдөөгүй байна.	1,089.0			1,089.00

5	Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр "Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх" төслийг хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд нийлүүлэгдсэн Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын нэр дээр бүртгэлтэй 72-63 УЕС улсын дугаартай Nissan, Navara-D40 маркийн суудлын авто машиныг балансаас балансад шилжүүлэн авах хүсэлтийг Хот тохижилтын газарт хүргүүлж, хариу авто тээврийн үндэсний төвийг нэр шилжүүлэх хүсэлт ирүүлснээр тус машиныг 2024 оны 11 дүгээр сарын 13-нд Хяналт шалгалтын газрын нэр дээр шилжүүлсэн боловч данс бүртгэлд тусгаагүй байна.	НИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журмын 5.1-д "Хуулийн этгээдийн дарга нь илүүдэлтэй буюу ашиглагдаггүй эд хөрөнгийг бусад байгууллага руу балансаас балансад шилжүүлэн өгөх болон бусад байгууллагын эзэмшилд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа энэ журмын 1.3-д заасан бичиг баримтыг бүрдүүлэн Өмчийн харилцааны газарт ирүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулан баланс тайланд хөдлөл өөрчлөлт хийнэ."-	-	-	-	-
Нийт			5,593.9	-	-	5,593.9

Илэрсэн асуудал бүрээр хариу арга хэмжээний төлөвлөгөөний дагуу өгөгдсөн зөвлөмж тус бүрд холбогдох тайланг нийслэлийн Дотоод аудитын албанд хугацаандаа ирүүлэхийг мэдэгдэж байна.
Дотоод аудитаар илэрсэн асуудалтай танилцаж, хүлээн зөвшөөрсөн:

НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЭНХБАЯР

Тамга

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

Б.БОЛОРМАА

